



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1108

Шивээговь сум

Газар өмчлөх эрхийг баталгаажуулах
тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжүүлсэнтэй холбогдуулан иргэн Элжигин овогт Ганболдын Бодьсүрэн нь сумын Засаг даргын 2009 оны 58 дугаар захирамжаар Бэхт 2а тоотод 5000 м2 газрыг өмчилсөн нь сумын Ерөнхий төлөвлөгөөтэй зөрчилдөж байгаа тул өөрийн хүсэлтээр тухайн газрын хэмжээг 2456 м2 болгож тухайн иргэнд өмчлөх эрхийг баталгаажуулсугай.

2. Өмчилж авсан тухайн газраа улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн /Ганболдын Бодьсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2009 оны 58 дугаар захирамжийн хавсралтын 5 хүснэгтэнд заагдсан Ганболд овогтой Бодьсүрэнд холбогдох газар өмчлөх эрхийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

421217 35